ЗАВХАН АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 04 сарын 16 өдөр Дугаар А/12 Улиастай

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг Эрүүл мэндийн сайдын 2023 оны "Журам шинэчлэн батлах, тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" А/383 дугаар тушаалаар батлагдсан журмын 1.9, аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн Б/54 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх "Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын ажиллах журмаар батлагдсан чиг үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлэн холбогдох хууль журмыг мөрдөн ажиллахыг комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтэс (Ж.Долгинсүрэн)-т даалгасугай.

4.Тушаал гарсантай холбогдуулан 2022 оны 11дүгээр сарын 30-ний өдрийн А/57 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА М.ҮРЖИНХАНД

АТА6681 9038051
0922010016

D:/Tushaal/ -2024

2024062000083

Эрүүл мэндийн газрын даргын 2024
оны 04 дүгээр сарын 16-ний өдрийн
...1... тушаалын хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийн комиссын бүрэлдэхүүн

Комиссын орлогч дарга	Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга
Гишүүд	Эрүүл мэндийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж хүртээмж, чанар аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн
	Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн статистик мэдээ мэдээлэл хариуцсан улсын байцаагч
	АЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн Монгол улсын хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн
	"Энхийн залуус ТББ"-ийн төлөөлөл
Комиссын нарийн бичиг	Эрүүл мэндийн газрын Хууль эрх зүй, эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хариуцсан мэргэжилтэн